

Маргааны товч

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагчийн 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 0003008 дугаартай шийтгэлийн хуудсаар Зөрчлийн тухай хуулийн 10.2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн “Содмонгол групп” ХХК-ийг чанар, стандартын шаардлага хангаагүй шатахуун худалдсан” зөрчил гаргасан нь улсын байцаагчийн дүгнэлт, лабораторийн сорилын үр дүнгээр нотлогдсон гэж үзэн есөн мянган нэгжээр торгох шийтгэл оногдуулжээ.

“Содмонгол групп” ХХК-аас дээрх шийтгэлийн хуудсыг эс зөвшөөрөн хүчингүй болгуулах шаардлага бүхий гомдол гаргаж, үндэслэлээ “... дээж авч шинжлүүлсэн үйл ажиллагаа нь холбогдох журмыг зөрчсөн, 2 дээжийн хариу зөрүүтэй гарсан байхад гурав дахь дээжийг дахин шинжилгээнд хамруулж шинжилгээний дүнг бүрэн нотлох ёстой байтал хэргийн оролцогчид гомдол, хүсэлт гаргах, дахин шинжилгээ хийх боломжийг олгоогүй нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой зөрчсөн, мэргэжлийн хяналтын байцаагчийн дүгнэлт үндэслэлгүй, тусгай мэдлэг, мэргэжил шаардсан асуудалд шатахууны чанар, стандарттай холбоотой мэргэжлийн байгууллагын оролцоог хангалгүйгээр хууль зөрчсөн шийдвэр гаргасан, хоёр лабораторид шинжилгээний аргын стандартын нэгдмэл байдлыг үндэслэж шинжилгээ хийж дүгнэлт гаргаагүй, лаборатори хоорондын хэмжлийн эргэлзээг тооцоогүй, лаборатори хоорондын багажийн зөвшөөрөгдөх алдаанаас илүү зөрүүтэй шинжилгээний дүгнэлтийг үндэслэж дүгнэлт, тайлан гаргасан, дээж аваад дизель түлш Евро-д баримталдаг стандартаар хэмжилт хийсэн нь хууль бус бөгөөд үнэнд нийцэхгүй, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн хууль бус дүгнэлтийг үндэслэн шийтгэл оногдуулсан ... нь эрх, ашиг сонирхлоо хамгаалах, өөрийн байрыг суурийг илэрхийлэх, нотлох баримт, мэдээлэл өгөх боломжгүй нөхцөл үүсгэсэн ...” гэж тодорхойлон маргажээ.

Харин хариуцагчаас “... Батлагдсан удирдамжийн дагуу хяналт шалгалтын бүрэлдэхүүнд Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Стандарт, хэмжил зүйн газар, Гаалийн ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Ашигт малтмал, газрын тосны газрын Уул уурхай, газрын тосны төв лаборатори, Иргэний нисэхийн үндэсний төвийн оношилгоо, хэмжил зүйн лаборатори зэрэг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан хамтран хийж гүйцэтгэсэн, дээж авах арга стандартын дагуу түүвэрлэгдсэн шатахуун түгээх станцуудын шатахуун түгээгүүрийн хошуу, савнаас авч, дээж тус бүрийг нууц кодоор кодолж Ашигт малтмал, газрын тосны газрын Уул уурхай, газрын тосны төв лаборатори, Иргэний нисэхийн үндэсний төвийн оношилгоо, хэмжил зүйн лабораторид хүлээлгэн өгсөн, тус компанийн албан хаагчдыг байлцуулан дээж авсан, хяналт шалгалтыг хуульд заасан журмын дагуу хийж гүйцэтгэсэн, сорилын дүн болон улсын байцаагчийн дүгнэлт гарсан учир хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн, Улаанбаатар хотоос дээж авсан учир алс холоос авч байгаа дээж буюу тээвэрлэж ирэх дээж гэж үзээгүй тул 45 хоногийн хугацаа дууссан тул Гаалийн ерөнхий газрын лабораторид хадгалагдаж байсан маргаан таслах дээжийг ажлын хэсгийн дүгнэлтээр “стандартад заасан хугацаа хэтэрсэн” үндэслэлээр устгалд оруулсан, улсын байцаагчийн дүгнэлтэд 18 үзүүлэлтээс 9 шаардлага хангаж байгаа гэж дүгнэсэн боловч нэг үзүүлэлтийг хангахгүй бол бүх шаардлагыг хангаагүй гэж үздэг, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан үүргээ биелүүлээгүй гэж үзэн Зөрчлийн тухай хуулийн 10.2 дугаар зүйлийн 5-д зааснаар шийтгэл оногдуулсан нь үндэслэлтэй, тухайн зөрчлийн ажиллагаа нь хяналтын прокурорын хяналт дор гүйцэтгэгддэг учраас манай байгууллагын эрх бүхий албан тушаалтан өөрийн эрх, үүргийн хүрээнд хууль тогтоомж зөрчсөн үйлдэл байхгүй ...” гэх агуулгаар гомдлыг эс зөвшөөрсөн хариу тайлбар гаргажээ.